

**Some reflections upon concepts of educational philosophies**

Gankhuyag Shagdar, Amantai Khajyet, Bolor-Erdene Oros, Byambasuren Jargalsaikhan

Article information**Article history:**

Received: 2024.11.05

Revised: 2024. 11.14

Accepted: 2024.11.20

Keywords:

Educational philosophy

Globalization

Cultural identity

Critical thinking

Lifelong learning

Progressive education

Perennialism

Critical pedagogy

Traditional Mongolian education

Development strategies

Ethical values

Policy framework

ABSTRACT

This paper explores the philosophical theories and paradigms of education, focusing on its goals, values, and policy implications in the context of globalization and cultural preservation. The study examines diverse educational philosophies, such as progressivism, perennialism, critical theory, and traditional Mongolian perspectives, highlighting their relevance to contemporary education. It emphasizes the integration of cultural identity and global competitiveness in Mongolian educational goals, proposing a framework that balances philosophical ideals with practical policy needs. By aligning educational philosophy with national development strategies, the paper advocates for a holistic approach to education that fosters critical thinking, ethical values, and lifelong learning.

Corresponding author:

Amantai Khajyet

Institute of Philosophy

Email: amanshahsoma@gmail.com

Боловсролын философийн үзэл баримтлалын тухай эргэцүүлэл

Шагдарын Ганхуяг, Хажетын Амантай, Оросын Болор-Эрдэнэ, Жаргалсайханы Бямбасүрэн

Санал болгож буй эшлэл:

Ганхуяг, Ш., Амантай, Х., Болор-Эрдэнэ, О., Бямбасүрэн, Ж. (2024). Боловсролын философийн үзэл баримтлалын тухай эргэцүүлэл. *Боловсролын Судалгааны Монголын Сэтгүүл, Тусгай дугаар*. <https://doi.org/10.46328/mjer.si.2024.08>

To cite this article:

Ganhyag, Sh., Amantai, Kh., Bolor-Edrene, O., Byambasuren, J. (2024). Some reflections upon concepts of educational philosophies. *Mongolian Journal of Educational Research, Special Issue*. <https://doi.org/10.46328/mjer.si.2024.08>

БОЛОВСРОЛЫН ФИЛОСОФИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛЫН ТУХАЙ ЭРГЭЦҮҮЛЭЛ

Дэлхий дахины нийгэм, эдийн засгийн байдал, шинжлэх ухаан технологийн хурдацтай хөгжил нь боловсролын үзэл баримтлалыг философийн үүднээс шинжлэн судлах хэрэгцээ шаардлагыг бий болгож байна. Иймээс боловсролын үндсэн зорилго, агуулга, үүрэг, ач холбогдол, боловсролын бодлого, хөгжлийн чиг хандлагыг оновчтой тодорхойлох явдал нь даяаршлын эрин үед уламжлалт соёл, ёс заншил, түүхээ хадгалж үлдэх, үндэсний онцлогоо хамгаалж бие даан орших чухал нөхцөл болох юм.

Бидний илтгэлийн зорилго бол манай улсад боловсролын ямар философи, бодлого хэрэгтэй байгаа талаар боловсролын философийн онолуудыг судлан шинжилсний дүнд монгол улсад боловсролын ямар бодлого байж болох талаар санал зөвлөмжөө дэвшүүлэхэд оршиж байна. Үүний тулд бид боловсролын гол гол тодорхойлолтыг танилцуулан улмаар боловсролын философи ба боловсрол дидактикийн онолуудын гол ялгааг гарган тавьж, цаашлаад академик ертөнцөд боловсролын ямар философийн үзэл баримтлалууд байдаг хийгээд тэдгээрийн зорилго, үнэт зүйл, нөлөө бүхий үзэл санааг авч үзээд үүн дээрээ эргэцүүлэл хийж боловсролын үзэл баримтлал нь улс орны хөгжлийн үзэл баримтлалтай яагаад уялдах ёстой, монголын боловсролын философийг тодорхойлоход юуг анхаарах шаардлагатайг хэлэлцэж дүгнэх юм.

Юуны түрүүнд боловсролын талаарх чухал хэдэн тодорхойлолтуудыг авч үзье.

Жон Дьюи “Боловсрол бол амьдралд бэлтгэдэг зүйл биш, харин амьдрал өөрөө юм” (Dewey, J. 1938) гэж бичжээ. Боловсрол бол тасралтгүй өсөж хөгжих, хувь хүний туршлагыг сэргээн шинэчлэх үйл явц гэдгийг онцлон тэмдэглээд түүний үзлээр боловсрол нь хувь хүний чадавхыг хөгжүүлж, нийгэмд утга учиртай оролцоход бэлтгэх нь чухал гэж үзсэн байдаг. Түүний онцолж байгаагаар боловсролд дасан зохицох (adaptive) болон туршлагын мөн чанар чухал үүрэгтэй ажээ.

П.Фрейре “Боловсрол нь багш шавь хоёрын хоорондын зөрчилдөөнийг шийдвэрлэж, хоёулаа адилхан багш, шавь болохын тулд зөрчлийн хоёр туйлыг уялдуулж чадсанаар эхлэх ёстой”¹ хэмээн үзэж боловсролыг хувь хүн өөрт нь тулгарч буй бодит байдалтайгаа шүүмжлэлтэй, ухаалгаар харьцах боломж олгох зорилго дээр үндэслэсэн, эрх чөлөөнд хүрэх, чөлөөлөгдөх үйл явц гэжээ. Тэрээр “Дарлагдагсдын педагог” бүтээлдээ боловсролын “бөөгнөрүүлэх загвар”-ыг (banking) шүүмжилж, түүний оронд суралцагчид мэдлэг бий болгох явцад идэвхтэй бүтээлчээр оролцдог диалогийн загварыг дэвшүүлсэн байдаг.

Социологич Э.Дюркхейм “Боловсрол бол залуу үеийнхнийг системтэйгээр нийгэмшүүлэх арга ухааныг хэлнэ” (Freire, P. 1970) хэмээгээд боловсролыг залуу үеийнхэнд нийгмийн хэм хэмжээ, үнэт зүйлсийг суулгаж, хувь хүмүүсийг хамт олон болгоход бэлтгэх арга хэрэгсэл гэж үздэг байв. Энэ нь нийгмийн нэгдмэл байдлыг хадгалахад боловсролын үүргийг онцолж буй хэрэг юм.

А.Эйнштейн “Боловсрол бол сургууль дээрээ сурсан зүйлээ мартсанаас үлдсэн зүйл юм” (Einstein, A. 1936) гэжээ. Түүний боловсролын талаарх үзэл баримтлал нь зүгээр л мэдээ баримтыг цуглуулах биш, харин шүүмжлэлтэй сэтгэх, мэдлэгийг бие даан эрэлхийлэхэд чиглэгдсэн байдаг ба жинхэнэ боловсрол бол чөлөөтэй сэтгэн бодох чадварыг хөгжүүлэх явдал гэж үзжээ.

Нидерландын философич М.Ж.Лангевельд “Боловсрол бол хариуцлагатай хувь хүнийг төлөвшүүлэх заавар (удирдамж) юм” (Langeveld, M.J. 1967) гэж тодорхойлжээ. Түүнийхээр боловсролын гол зорилго бол ёс суртахууны зан чанар, бие даасан байдлыг хөгжүүлэх, ингэхдээ боловсролын үүрэг нь суралцагсдыг өөрсдийн нөөц боломжоо илрүүлэн хөгжүүлэхэд нь удирдан чиглүүлж, дэмжих явдал юм гэж үзсэн байдаг.

Эдгээр тодорхойлолтуудаас эрдэмтдийн олонхид зөвшөөрөгдсөн нь А.Эйнштэйнийх бөгөөд нийгэм болон хувь хүний түвшинд ч бүхэллэг шинжтэй боловсролын бүх аспектиг багтаасан, тасралтгүй танин мэдэх, хөгжихийг зааснаараа цогц тодорхойлолт болж чадаж байгаа юм.

Онцлон тэмдэглэхэд боловсрол нь суралцах, мэдлэг чадвар эзэмших, төлөвших явц, туршлагажих хүний идэвхтэй үйл ажиллагааг илэрхийлэх ойлголт болж байна. Өөрөөр хэлбэл, боловсролыг бид энгийнээр ойлгоё гэвэл сурч боловсроод тодорхой мэдлэг чадвар олж авсны үр дүнд (дагуур байдлаар /побочны/) хүмүүжин төлөвшиж “ухамсартай хүн” болох цаашлаад “ухамсартай нийгмийн” гишүүн болох үйл явц гэж ойлгож болохоор байна.

Ерөөс боловсрол бол өөрөө зорилго биш харин **арга зам, хэрэгсэл** гэдгийг ойлгох нь чухал. Бид мэдлэг, мэдээлэл, ур чадвар, туршлагыг сурч эзэмшсэнээрээ хувийн болон нийгмийн түвшинд тодорхой

зорилгод хүрэх бололцоотой болдог гэсэн үг юм. Тиймээс боловсролын бодлого явуулж буй төр засгийн байгууллагын зорилго бол боловсролын үйл явц дахь ямар нэг хүндрэл саад бэрхшээлийг арилгах, боловсролыг хөхүүлэн дэмжихэд чиглэгдэж буй үйл ажиллагаа болж байна.

Өнөөдрийн хурлын хэлэлцэх сэдвийн хүрээнд нийгмийн түвшинд буюу нийт хүмүүсийг багтаасан өргөн хүрээний боловсролыг хэрхэн хөгжүүлэх вэ, ингэхдээ иргэдэд боловсрол эзэмшихэд нь тэгш боломжоор хэрхэн хангах вэ, тулгарч буй саад бэрхшээлийг хэрхэн даван туулах вэ, тэгш хүртээмжтэй боловсролыг хэрхэн олгох вэ зэрэг ерөнхий асуудлуудыг судлахад нэн түрүүнд төр бодлого гаргагч субъект болохынхоо хувьд боловсролын тухай бодлогоо тодорхой үзэл баримтлал, философи дээр тулгуурлан боловсруулах нь зайлшгүй шаардлагатай гэсэн үндэслэлийг дэвшүүлж байна.

Энд нэгэн зүйлийг тодруулах нь зүйтэй болов уу. Юу гэвээс боловсролын философи гэж юу вэ? боловсролын философи үзэл баримтлалууд нь боловсролын буюу дидактикийн шинжлэх ухааны онолуудаас юугаараа ялгаатай вэ? хэмээх ойлголт юм. Учир нь эдгээр ойлголтуудыг ялгаж заагласнаар агуулгын хүрээ, судлах зүйлийн хил хязгаар оновчтой болох юм.

Юуны түрүүнд дээрх хоёр ойлголт нь хандлага, зорилгоороо ялгагддаг гэж хэлж болно. Боловсролын философийн онцлог бол философийн сэтгэлгээний уламжлалд тулгуурлан боловсролын зорилго, үнэт зүйлс, ёс зүйн хэм хэмжээ нь юу байх вэ гэдгийг авч үзэн тодорхойлохыг зорьдог. Тухайлбал, боловсролын философид хөндөгддөг гол асуултууд бол “боловсролын зорилго” гэж юу? “мэдлэг” гэж юу вэ? “боловсрол” нь нийгмийг хэрхэн өөрчлөн хэлбэршүүлэх ёстой вэ? гэх мэт асуултуудыг тавьж хариулах гэж оролддог. Жишээ нь Ж.Дьюгийн прогрессив онолоор, ардчилсан иргэнийг төлөвшүүлэх гол арга бол туршилтаар танин мэдэх, суралцах үйл явц, харин Фрейрегийн шүүмжлэлт онолоор, боловсрол нь эрх чөлөөнд хүрэх, нийгмийн шударга байдалд хүргэх хэрэгсэл гэдэг. Эдгээр боловсролын философийн онолууд нь яагаад бид боловсрол эзэмшдэг, яагаад бид боловсрох ёстой вэ? Боловсрол нь ёс суртахууны болон нийгмийн ямар зорилгод үйлчлэх ёстой вэ гэдгийг тодорхойлохыг оролддог.

Тэгэхдээ философийн нэг онцлог нь оюуны эргэцүүлэн бясалгал, хэм хэмжээний хүрээнд тулгуурладаг бол шинжлэх ухаан бол бодит туршлага дээр тулгуурладаг. Тиймээс боловсролын философи нь метафизик, ёс зүй, эпистемологи гэх мэт өргөн хүрээний философийн салбаруудаас уламжлан авч үзсэн үнэт зүйлс, ёс зүй, туйлын зорилго гэх мэт ойлголтуудад анхаарлаа хандуулдаг. Тэр утгаараа боловсролын философи нь заах арга зүйн тодорхой нэг аргачлалууд биш үзэл баримтлалын болон ёс зүйн үндсийг нь эргэцүүлэн боддог гэсэн үг. Тухайлбал, Ж.Дьюи хэлэхдээ “философийн онолууд нь боловсролын зорилгуудыг болон бидний тэмүүлэх идеалуудыг шүүн шинжлэн үнэлж дүгнэхийг зорьдог” (Dewey, J. 1916) гэжээ.

Тэгвэл боловсролын шинжлэх ухааны заах арга зүйн онолуудын онцлог бол өөр. Тэр нь ихэнхдээ сэтгэл судлал, нейросайенс буюу мэдрэлийн шинжлэх ухаан зэрэгт тулгуурладаг бөгөөд эмпирик туршлагын арга, мөн тестлэн шалгаж болох аргазүйг ашиглан, суралцах гэж юу вэ? суралцах процесс хэрхэн явагддаг вэ?, ямар арга зүй хамгийн үр дүнтэй байх вэ? ямар төрлийн заах арга барил нь тогтоох, ойлгох чадварыг сайжруулдаг вэ? зэрэг асуултуудад хариу өгөх гэж оролддог. Жишээлбэл, Скиннерийн бихевиоризм нь хэмжигдэж болох суралцах зан байдал дээр төвлөрдөг бол Ж.Пиже, Л.С.Выготский нарын конструктивизм нь нийгмийн харилцаа болон туршлагаар дамжин мэдлэг хэрхэн бүтээгддэгийг онцлон судалдаг.

Эндээс боловсрол судлалын онолууд нь илүү эмпирик туршлага дээр суурилахын зэрэгцээ суралцах үйл явцын механизмыг судалдаг нь харагдаж байна. Өөрөөр хэлбэл, туршилтын өгөгдлүүд, статистик шинжилгээ, нотолгоо баримтад тулгуурлан аливаа онолын тайлбараа үндэслэдэг гэсэн үг. Философийн онолуудаас ялгаатай нь боловсрол судлал нь суралцахуй хэрхэн өрнөдөг, практик дээр ямар аргачлал илүү үр дүнтэй вэ? гэдэг асуудалд голчлон төвлөрдөг. Үүнийг Б.Ф.Скиннер тодорхойлохдоо “боловсрол дахь шинжлэх ухааны онолууд нь үр дүнтэй заан сургах, суралцах ажиллагааг дэмждэг үйл явц, сургах стратегийг ойлгохын тулд эмпирик ажиглалт, нарийн хяналттай туршилт дээр тулгуурладаг” (Skinner, B.F. 1953) гэсэн байна. Тэгэхээр боловсролын философи нь боловсролын зорилго, үнэт зүйлүүдийг тодорхойлж, ёс суртахууны суурь чадваруудыг эзэмшүүлдэг, харин боловсрол судлалын онолууд нь тэдгээр зорилгод хүргэх баримт нотолгоонд тулгуурласан практик арга, аргачлалыг боловсруулан хөгжүүлэхэд оршино.

Орчин үед боловсролын философийн ямар үзэл баримтлалууд бий болсон байна вэ? Тэдгээр нь ямар

зорилго, үнэт зүйлийг номлодог вэ? гэдэг талаар товчхон тоймлоё.

Одоогоор боловсролын философид танигдсан хэд хэдэн онол бий. Үүнд:

1. **Перенниализм:** Мөнхийн тогтмол гэсэн утгатай үгнээс үүдэлтэй. Гол төлөөлөгчид нь: Мортимер Адлер, Роберт Хатчинс нар.

Онолынх нь гол санаа бол боловсрол нь цаг хугацааны шалгуурыг давж гарсан үзэл санаа, үнэн дээр төвлөрөх ёстой гэж үздэг ба сонгодог зохиол, тусгай бүтэцтэй сургалтын хөтөлбөрийн дагуу заах ёстой гэж үздэг.

Давуу тал: Шүүмжлэлт сэтгэлгээг голчлон дэмжиж цаг үеийн бус мөнхийн асуултуудыг (философийн) асуух, хэлэлцэх арга барилга ашиглахын зэрэгцээ оюун ухааны сахилга батыг чухалчилдаг.

Сул тал: Цаг үетэйгээ заримдаа нийцэхгүй байх магадлалтай, тогтмол чанартай байх хандлагатай, мөн хэт ерөнхий зүйл номлодог учраас практик хэрэглээний асуудал дутмаг.

Роберт М.Хатчинс: “Боловсролын зорилго нь залуучуудыг насан туршдаа өөрсдийгөө боловсролтой болгоход бэлтгэх явдал мөн” гэсэн эшлэл нь мөнхийн үзэл, санаануудыг танин мэдэж ухаарч ойлгох замаар насан туршдаа суралцах, оюун санааны хөгжилд итгэх итгэл үнэмшлийг онцолж буй юм.

2. **Прогрессивизм:** гол төлөөлөгч нь Жон Дьюи.

Онолын зорилго нь практик дээр туршиж, хийж байж суралцдаг, мэдлэгийг практикт ашиглаж чаддаг идэвх санаачилгатай, сониуч хүүхдийг бойжуулахыг гол болгодог. Хувь хүний болон нийгмийн өсөлт хөгжлийг чухалчилж сурагчдын ардчилсан нийгэм үр дүнтэйгээр оролцоход бэлтгэх зорилготой.

Сайн тал: мэдлэгийг олж авах хамгийн үр дүнтэй арга бол амьдрал практик дээр хэрэглэх, турших гэж үздэг.

Сул тал: Боуд зэрэг төлөөлөгчид хувь хүний туршлагыг хэт голчлох нь яг таг байдал, системтэй мэдлэг олж авах арга замыг багасгадаг гэж шүүмжилдэг.

Жон Дьюигийн “Боловсрол бол амьдралд бэлтгэх бэлтгэл биш, боловсрол бол амьдралын үйл явц (амьдрал) өөрөө юм” гэсэн тодорхойлолт нь боловсролыг хувь хүний болон нийгмийн өсөлт хөгжилттэй салшгүйгээр нэгдэн нийлсэн туршлага, насан туршийн үйл явц гэсэн санаа юм.

3. **Эссенциализм:** гол төлөөлөгч нь Уильям Баглэй.

Суралцагчдыг амьдралдаа амжилт үзүүлэхэд нь бэлтгэх ур чадвар, мэдлэгийг гол зорилго үнэлэмжээ болгодог. Ёс зүйн хувьд сахилга бат, ихэс дээдэс удирдлагуудыг хүндлэх, хариуцлагатай иргэн бэлтгэхийн тулд хатуу чанд хичээл сургалтыг үнэлэмжээ болгодог.

Үндсэндээ эссенциализм нь сургалтын суурь (цөм) хөтөлбөрийг номлож, математик, байгалийн суурь ухаанууд, түүх, хэл зүй гэх мэт суурь шинжлэх ухааны мэдлэг эзэмшүүлэхийг чухалчилдаг үзэл юм.

Сайн тал нь энэ боловч дутагдалтай тал нь дэндүү хатуу чанд байж, суралцагчийн дур сонирхол, бүтээлч байдлыг орхигдуулдаг гэж зарим шүүмжлэгчид үздэг.

Уильям Баглэй “Боловсролтой хүний эзэмшсэн байх ёстой маш чухал суурь ур чадвар, мэдээлэл байдаг” гэдэгт эссенциалистууд итгэдэг. Энэ нь эссенциалист боловсрол бол тэрхүү суурь мэдлэг, ур чадварыг агуулдаг суурь сургалтын хөтөлбөрт тулгуурладаг гэдгийг харуулж буй.

4. **Реконструкционизм:** гол төлөөлөгч нь Теодор Бремилд.

Онолын үндсэн зорилго нь нийгмийн асуудлуудыг боловсролоор дамжин шийдвэрлэх гэж оролдон ингэснээрээ илүү тэгш шударга нийгмийг бий болгоход орших юм. Ёс зүйн хувьд нийгмийн шударга ёс, хүнийг илүү эрх, боломжтой болгох, суралцагчдыг өөрчлөгч, шинэчлэгч болгоход зорих ёстой гэж номлодог. Реконструкционист үзэл нь боловсролоор дамжуулан нийгэм, улс төрийн шинэчлэлийг бий болгох, суралцагчдыг нийгмийн аливаа хэм хэмжээнд шүүмжлэлтэй хандан,

шинэчлэхэд урамшуулан дэмждэг үзэл болой.

Сайн тал нь хэдийгээр нийгмийн өөрчлөлтийн төлөө тэмүүлдэг, идэвхтэй иргэд болоход урамшуулан дэмждэг боловч сул тал нь хэт улс төржсөн, эрдэм шинжилгээний мэдлэгээс сатаарсан гэж шүүмжилдэг. Теодор Брамелд “Боловсрол юуны түрүүнд шинэ нийгмийн дэг журам бий болгоход чиглэсэн байх ёстой” гэсэн нь боловсролыг нийгмийн шинэчлэлийн хэрэгсэл болгон ашиглаж, боловсролоор дамжуулан нийгмийн жишиг хэм хэмжээнүүдийг дахин үнэлж цэгнэхийг уриалсан реконструкционизмын зорилгыг харуулж байна.

5. **Экзистенциализм:** Гол төлөөлөгчид нь Жан Поль Сартр.

Онолын зорилго нь бие хүнийг төлөвшүүлэх, хувь хүний хариуцлагатай байдал, суралцагч суралцах арга барилаа олохыг дэмжихэд чиглэнэ. Ёс зүйн хувьд суралцагчдад өөрийн үнэ цэнэ, зорилгоо тодорхойлох боломжийг олгосноор өөрийгөө таньж мэдэх, өөрийнхөөрөө байхыг чухалчилдаг. Тэгэхээр экзистенциалист үзэл баримтлал нь эрх чөлөө, өөрийгөө тодорхойлох зарчмыг номлож, тэгснээрээ суралцагчыг суралцах өөрийн арга барилаа олох боломж нь олдоно гэж үздэг. Хэдийгээр экзистенциализм нь суралцагчийн бие даасан байдал, хувь хүний үүрэг хариуцлагыг дэмждэг ч гэсэн, нөгөө талаас шүүмжлэгчдэд энэ нь хэт субъектив, амьдралын практик ур чадварыг хөгжүүлэх системээр дутмаг байж болно гэж үздэг байна.

6. **Конструктивизм:** Гол төлөөлөгчид нь Жан Пиаже.

Онолын гол зорилго нь суралцагчийн идэвхтэй оролцоотойгоор мэдлэг бий болгох зорилгод чиглэгдсэн сурагч төвтэй, туршлагад тулгуурласан суралцахуйг номлодог байна. Чингэхдээ ёс зүйн хувьд суралцагчийн бие даасан сонголт үйл ажиллагаанд чухалчилж, шүүмжлэлтэй сэтгэх, асуудлыг хамтран шийдвэрлэхийг дэмждэг үзэл номлол юм. Конструктивист онолын гол үзэл санаа бол суралцах гэдэг нь суралцагсад хүрээлэн буй орчинтойгоо болон бусадтайгаа харилцах харилцаагаар дамжуулан тэднийг ойлгох ухааныг хөгжүүлдэг идэвхтэй үйл явц гэж хэлж болно.

Сайн тал нь шүүмжлэлт сэтгэхүйг чухалчилснаар танин мэдэхүйн хөгжлийг дэмждэг боловч дутагдалтай тал нь уламжлалт боловсролын бүтцийн үүднээс суралцагчийг үнэлэхэд хэцүү, бэрхшээлтэй байдаг гэж үздэг байна.

7. **Бихевиоризм:** гол төлөөлөгч нь Скиннер.

Онолын гол зорилго нь мэдлэгийг бататгах замаар суралцагчийн эерэг зан байдлыг урамшуулан дэмжихийн тулд ажиглагдахуйц, хэмжиж болохуйц үр дүнг голчилдог. Ёс зүйн талаасаа хүсүүштэй зан байдлыг төлөвшүүлэх замаар үр бүтээлтэй, биеэ зөв авч явдаг бие хүнийг бий болгох зорилготой. Гол санаа нь бол бихевиоризм нь сургалт нь урамшуулан бататгах болон шийтгэх замаар бүрэлддэг бөгөөд багш, сургагч нь суралцагчийн зан байдлыг системтэйгээр урамшуулах замаар чиглүүлэх ёстой гэж номлодог. Сайн тал нь зан байдлын сургалт болон ур чадвар эзэмшүүлэхэд өндөр үр дүнтэй боловч дутагдалтай тал нь дотоод сэтгэлгээний үйл явцад анхаарал хандуулдаггүй, бүтээлч байдлыг хязгаарладаг гэж үздэг.

8. **Шүүмжлэлт онол:** Гол төлөөлөгчид нь Пауло Фрейре.

Боловсролын шүүмжлэлт онол нь маргинал дуу хоолойг сонсож тэдэнд эрх боломжийг олгох, эрх мэдлийн хөгжил хувьсалд дүн шинжилгээ хийх, нийгмийн шударга ёсыг дэмжихийг чухалчилдаг. Энэ нь суралцагчдыг нийгмийн тэгш бус байдалд шүүмжлэлтэй хандах, боловсролыг эрх чөлөөнд хүрэх хэрэгсэл гэж үзэн, байгаагаа тогтсон байдлыг үгүйсгэдэг. Энэ онолыг нийгэм, улс төр, эдийн засгийн бүтцийн талаар шүүмжлэлтэй сэтгэхийг хөхүүлэн дэмжиж, дарангуйлал, шахалт хавчилгын эсрэг идэвхтэй тэмцдэг болж хүмүүжихийг зорилго болгодог.

Пауло Фрейре: “Боловсрол нь нэг бол залуу үеийнхнийг өнөөгийн тогтолцооны логикт нэгтгэж, нийцлийг бий болгодог хэрэгсэл болж үйлчилдэг эсвэл эрх чөлөөний практик хэрэгжилт болж, эрэгтэй, эмэгтэй хүмүүс бодит байдалд шүүмжлэлтэй, бүтээлч байдлаар харьцаж, хүрээлэн буй нийгэм ертөнцөө өөрчлөхөд хэрхэн оролцохыг нээн илрүүлэх арга хэрэгсэл болдог” гэсэн нь суралцагчид нийгмийн бүтцийг сорин шүүмжилж, өөрчлөх эрх мэдэл олгох шүүмжлэлт онолын зорилгын гол цөм юм.

Ерөнхийдөө маргинал дуу хоолойг дэмжих, нийгмийн тэгш байдлыг хөхүүлэн дэмжих, оюутнуудыг шударга ёсыг хамгаалахад бэлтгэгдсэн, идэвхтэй, мэдлэгтэй иргэд болон төлөвшихийг урамшуулан дэмждэг мөн ардчилсан үнэт зүйлсийг дэмжихийг эн тэргүүнд тавьдаг гэж хэлж болно.

Тоймлон авч үзвээс, эдгээр боловсролын философи үзэл баримтлалуудын зорилго нь голчлон сурагч өөрөө идэвхтэй байх, туршиж үзэх, өөрийгөө олж нээх, бүтээлчээр мэдлэгийг бий болгох, гүн мэдлэг, мөнхийн үнэнийг ухаарах, нийгэмд эергээр нөлөөлөх, нийгмийн идэвхтэй гишүүн байх, шүүмжлэлтэй хандах, эрх чөлөөтэй байх, эрх чөлөөг ухамсарлах гэх мэт хүний өөрийн нөөц боломжоо нээж илрүүлэн танин мэдэж, бусдад болон нийгэмд эерэгээр нөлөө үзүүлэх зэрэг зорилгууд байгаа бөгөөд энэ нь хүнийг ямар нэг үзэл суртлын бүтээгдэхүүн болгож төлөвшүүлэх биш, харин хүн өөрөө төлөвшихөд нь тус дэм болсон тухайн нийгмийнхээ үнэт зүйлийг ухаарах чадварыг олгоход зорьж байгаа нь харагдаж байна.

Өмнө дурдсанаар, боловсрол нь нэг талаас хэрэгсэл мөн боловч үүнийг манайхан хэт мушгин тодорхой үзэл суртлын бүтээгдэхүүн болгох тал ажиглагддаг. Тухайлбал, социалист хүн болох эсвэл капиталист хүн болгох гэх мэт. Дээр дурдсан үзэл баримтлалуудын зорилго, мөн чанаруудаас харвал мэдлэг, ур чадварынхаа тусламжтайгаар суралцагч нь амьдралд болон нийгэмд өөрийгөө хэрхэн авч явах, ямар байр суурь эзлэх, ямар үүрэг гүйцэтгэхээ өөрсдөө шийдэх боломжийг олгож байгаа юм. Өөрөөр хэлбэл, суралцагчдад “бэлэн хоол” буюу бэлэн үзэл номлолыг тулган хэвшүүлэх бус эрүүлээр сэтгэн бодох, биеэ зөв авч явах зан байдлыг төлөвшүүлэх буюу “загас барих аргыг” нь зааж сургахад оршиж буйг та бүхэн ойлгож байгаа бизээ.

Тэгвэл загас барих “ямар арга барилд” сургах ёстой юм бэ гэдэг асуулт зүй ёсоор гарч ирнэ. Түүний хариулт нь бид нийгмээрээ, улс орноороо хаашаа тэмүүлж байгаа вэ? Юуны төлөө хөгжин дэвшиж байна вэ? Ямар нийгмийг бүтээх гэж байна вэ? Хөгжлийн ямар бодлого баримталж байна вэ? гэдэгтэй зүй ёсоор холбогдож байгаа юм. Тиймээс бид ямар нийгэм байгуулах гэж зорьж байна, хөгжлийн ямар зорилго тавьж байгаагаас шалтгаалаад боловсролын зорилго, философио тэрхүү хэрэгцээ шаардлагад нийцүүлэн тодорхойлох шаардлагатай болж байгаа юм.

Нэг зүйлийг онцлоход дээр дурдсан онолуудад барууны улс орнуудаас гаралтай үзэл баримтлалууд байгаа нь илэрхий, гэтэл манай улс азийн улс орон. Хэдийгээр дурдагдсан үзэл баримтлалууд “философи үзэл” гэдэг утгаараа универсаль шинжтэй боловч бүс нутгийн онцлог, соёлын тодорхой хүчин зүйл боловсролд байх ёстой нь дамжиггүй юм. Тэгэхээр дорно дахинд боловсролын ямар ямар үзэл баримтлалууд байж ирснийг тоймлон бичих нь зүйтэй.

Хятадад Күнзийн боловсролын үзэл баримтлал, Энэтхэг, Төвд, Төв азид Буддын болон Хятадын Даосист боловсролын үзэл баримтлал, Өмнөд Ази, Энэтхэгт Хиндүизмийн боловсролын үзэл баримтлал, Ойрх дорнодод Исламын боловсролын үзэл баримтлал голчилдог гэж үзэж болно. Эдгээр номлол бүрийг авч үзвэл илтгэлийн цаг, бичвэр сунжрах учир буддын боловсролын үзэл баримтлалыг товч дурдаад Монголын боловсролын асуудал руу оръё.

Буддын боловсролын гүн ухааны гол зорилго нь энэрэнгүй үзэл хийгээд билиг оюуныг хөгжүүлэх замаар хүн өөрийгөө гэгээрэлд хөтлөхөд сургах явдал юм. Тухайлбал, хүн өөрийнхөө сэтгэлийн эзэн болоход тустай *mindfulness* буюу сэрэмж (санамсар)-ийг хөгжүүлэх бясалгал нь эдүгээ дэлхий нийтийн анхаарлын төвд ороод байна. Энэ нь орчин үеийн нийгэмд тулгамдсан сэтгэл гутрал, уур бухимдал, анхаарал төвлөрөл болон зүдэргээтэй бодол санаа зэрэг сэтгэлзүйн асуудлуудаас ангижрахад үр нөлөөтэй болохыг судлаачид онцолдог. Эцсийн дүндээ сэтгэлийн амар амгалан байдлаас нийтийн энх тайван байдалд хүрэхийг зорьдог. Тэгэхээр Буддын боловсролын онцлог нь зөвхөн дотогшоо чиглэсэн буюу өөрийгөө олох, бясалгах, эргэцүүлэх явдал төдийгүй бусдыг ойлгож, хүндэлж энэрэх, бусдад туслахад, буян хүргэхэд орших ба илүү ёс суртахууны шинж чанартай боловсрол байдгийг онцлох нь зүйтэй.

Монголчуудын уламжлалт боловсрол хүмүүжлийн тогтолцоонд ахуй амьдралаа арга билгийн ухаанаар хөтөлж авах гээхийн ухаанд суралцах нь чухал гэдгийг эртний домог, тууж, судар бичгүүдээс харж болно. Манай улсын иргэдийн ёс суртахуун доголдож байгаа шалтгааны нэлээд хувь нь уламжлалт эрдэм мэдлэг, зарчим, үнэлэмж алдагдсантай холбоотой. Иргэний хүмүүнлэг ардчилсан нийгэм цогцлоохын тулд юм бүхнийг шинээр эхлэх биш, өмнөх үеийн ёс журам, зан аалийн сайн зарчмууд, үнэлэмж ба хүмүүнлэг эрхэмлэлийг дахин сэргээж хэвшүүлэх ёстой (Ган-Өлзий Ч. 2019).

Аливаа нийгмийн хөгжил нь уламжлал, шинэчлэлийн зохист харилцаанд үндэслэгддэг. Тиймээс уламжлалын зохист хэм хэмжээг орхигдуулан нэг талыг барьсан өрөөсгөл хандлага сөрөг зүйлд хүргэдэг шалтгаан болохыг өнөөдрийн боловсролын бодлогын туйлбаргүй, залгамж холбоогүй гэнэтийн шийдвэр дүгнэлтүүдээс харж болно. Хэдийгээр дэлхийн улс орнуудын хоорондын харилцан хамаарал сайжирч, тэдгээрийн хурдацтай хөгжил зэргээс даяаршлын хүн төрөлхтөнд бий болгож буй маш олон давуу тал, ач холбогдлыг харж болох ч сөрөг талууд ч бий. Иймээс боловсролын тогтолцоонд өнгөрсөн түүхээр бүтээгдсэн ахуй, соёл, уламжлалт зан заншил, гоо зүй, ёс зүй, амьдралын хэв маяг, ёс журам зэрэг үндэсний онцлогоо орхигдуулалгүй байвал зохилтой.

Монголын боловсролын зорилгын философийн асуудалд дараах аспектүүд багтсан байх нь чухал хэмээн бид үзэж байна. Үүнд:

- Боловсролын бодлого, зорилго нь монгол хүний адилсал буюу мөн чанарыг, дангааршлыг хадгалах. Өөрөөр хэлбэл, Монгол соёл уламжлалын өвөрмөц шинжийг хадгалсан байх (Mongolian identity), цаашлаад буддын боловсролын болон ёс зүйн суурь үнэт зүйлс, сэтгэлгээний чадварууд шингэсэн байх. Тухайлбал, нигүүлсэнгүй, хүнлэг энэрэнгүй үзлийг сургах, монгол ёс суртахууны үнэт зүйлсийг хадгалсан, ахмад үеэ хүндлэхийг нийтлэг үнэт зүйлээ болгож болно.
- Эрүүл саруулаар сэтгэн бодох чадвар, орчин үеийн суралцахуйн суурь ур чадваруудыг эзэмшсэн буюу дээр дурдсан боловсролын философийн үзэл баримтлалууд дахь гол чадварууд багтсан байх. Тухайлбал, бүтээлч сэтгэлгээ, мэдлэгийг өөрөө эрэлхийлэн туршиж олж авах, шүүмжлэлтэй хандах, бие даан сурч судлах, бие даасан шийдвэр гаргаж сурах, хүрээлэн буй нийгэм, орчноо зөв үнэлж дүгнэх, буруу зөвийг ялгаж сурах гэх мэт.
- Амьдран буй нийгэмдээ эерэгээр хувь нэмэр оруулах, бүтээлч идэвх санаачилгатай болох (хувь хүний эрх, эрх чөлөөний мэдрэмжтэй), өөрөөр хэлбэл, ардчиллын үнэт зүйлсийг хүндлэх чадвартай буюу дээр дурдсан чадварууд багтсан (ардчиллын үнэт зүйлсийг дээдэлдэг байх, хариуцлагын ухамсартай, бие даасан үзэл бодол, шийдвэр гаргаж чаддаг, бүтээлч шүүмжлэлт сэтгэлгээтэй, нийгмийн харилцаанд ухамсартай оролцох чадвар бүхий, биеэ авч явах чадвартай, соёлын ялгаа, олон ургалч үзэл байдлыг хүлээн зөвшөөрөх) гэх мэт элементүүдийг оруулах нь чухал.

Товчхондоо боловсрол нь үндэсний ахуй соёлынхоо онцлогийг хадгалсан, дэлхийн хэмжээний боловсрол эзэмшсэн, дэлхийд өрсөлдөх чадвартай, ардчилсан нийгмийн үнэт зүйлсийг эрхэмлэх иргэнийг хэрхэн сургаж, төлөвшүүлэх вэ? гэдэгт гол анхаарлаа хандуулж ажиллах нь нэн шаардлагатайг дахин өгүүлье.

Гэхдээ энэ бол зөвхөн философийн талаас нь авч үзсэн боловсролын асуудал, харин үүнийг улс орны ирээдүйн зорилго, хөгжлийн алсын хараатай уялдуулан авч үзвэл арай өөр дүр зураг гарах учиртай. Яагаад гэвэл улс орон нийгмийн хөгжлөөс ангид боловсрол хөгжих бололцоогүй гэдэгтэй хэн ч маргахгүй бизээ. **Боловсролын институтууд нь өөрөө дотроо улс төрөөс ангид байх ёстой боловч бүхэллэг утгаараа улс орны хөгжлийн нэг суурь хэсэг болохынхоо хувьд боловсролын бодлого нь өөрөө улс орны хөгжилтэйгөө салшгүй уялдах ёстой болж байгаа юм.** Өөрөөр хэлбэл яагаад сурах, суралцах, сургах ёстойг нь хөгжлийн бодлого нь тодорхойлж, яаж сургах, сурахыг нь боловсролын институтууд өөрсдөө шийдэх ёстой юм.

Эцэст нь манай өнөөгийн боловсролын зорилго суурь баримт бичгүүдэд юу гэснийг авч үзье:

- Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг болох “Алсын хараа – 2050”-д боловсролын зорилгыг “*хүний хөгжлийг дэмжих, дэлхийн иргэн болох чадварыг эзэмшсэн, бүтээлч, хариуцлагатай, нийгмийн хөгжилд хувь нэмэр оруулах чадвартай, өрсөлдөх чадвартай иргэн төлөвшүүлэх*” гэж тодорхойлсон байдаг.
- Одоо хэрэгжиж буй “Боловсролын ерөнхий хууль”: “Монгол Улсын **боловсролын зорилго нь хүн бүрд чанартай боловсрол эзэмших тэгш боломж бүрдүүлж, насан туршидаа суралцаж, ажиллах, ёс суртахуунтай, сайн зан чанартай иргэнийг төлөвшүүлэхэд оршино**” хэмээн боловсролын хуулийн зорилгоо тодорхойлжээ.

- Харин “Боловсролын салбарын хөгжлийн дунд хугацааны хөтөлбөр”-д боловсролын зорилгыг “Монгол Улсын иргэний хөгжлийн хэрэгцээг хангахуйц чанартай, нээлттэй, тэгш хүртээмжтэй, уян хатан боловсролын үйлчилгээнд тулгуурлан мэдлэгт суурилсан нийгэм болон дижитал технологийн эринд ажиллаж амьдрах нийгмийн идэвхтэй оролцоо бүхий, тасралтгүй хөгжих чадамжтай иргэнийг цогцоор нь хөгжүүлэх” хэмээн томъёолсон байна.

Эндээс харахад өнөөгийн боловсролын зорилго, бодлогод монгол хүний дангааршлын асуудал, монгол хүн болж хүмүүжих ёс зүйн үнэт зүйлс тусгагдаагүй нь харагдаж байна. Мөн хүний танин мэдэх, сурч боловсрох суурь чадварууд, бүтээлч шүүмжлэлтэй сэтгэхүй зэрэг ардчиллын үндсэн үнэт зүйлсийг багтаагаагүй нь харагдаж байна. Иймд бид боловсролын зорилго, бодлогодоо уламжлалт өв соёл, үнэт зүйлсээ шингээх, хүмүүнлэг ардчилсан нийгмийг байгуулах гэж байгаагийн хувьд ардчиллын үнэт зүйлсийг төлөвшүүлэх чадваруудыг оруулах нь нэн чухал гэж үзэж байна.

НОМ ЗҮЙ

- Бэгз, Н., Пүрэв, О., Энхцогт, Н., Баттогтох, Д., Баярцэцэг, Б., Мягмар, П., Лхагвасүрэн, Ц., Тунгалаг, П. (2012). Боловсролын философи. Улаанбаатар: Соёмбо Принтинг.
- Хавх, Н. (2004). Боловсролын гүн ухаан, Улаанбаатар: Бит Сервис.
- Монгол дахь боловсролын философийн асуудал, хандлага. (2022). ЭШХ-ын эмхэтгэл, эмх. М.Золзаяа, П.Мягмарсайхан. Улаанбаатар: Соёмбо Принтинг.
- Adler, M. J. (1982). *The Paideia Proposal: An Educational Manifesto*. Macmillan.
- Apple, M. W. (1995). *Education and Power*. Routledge.
- Bagley, W. C. (1934). *Education and Emergent Man*. Nelson-Hall.
- Bestor, A. E. (1956). *Educational Wastelands: The Retreat from Learning in Our Public Schools*. University of Illinois Press.
- Biesta, G. (1998). Say You Want a Revolution... *Suggestions for the Impossible Future of Critical Pedagogy. Educational Theory*, 48(2), 229-239.
- Bode, B. H. (1927). *Modern Educational Theories*. Macmillan.
- Brameld, T. (1950). *Patterns of Educational Philosophy: A Democratic Interpretation*. World Book Company.
- Carnoy, M., & Samoff, J. (1990). *Education and Social Transition in the Third World*. Princeton University Press.
- Chomsky, N. (1959). *Review of B.F. Skinner's Verbal Behavior. Language*, 35(1), 26-58.
- Counts, G. S. (1932). *Dare the School Build a New Social Order?* John Day Company.
- Dewey, J. (1916). *Democracy and Education: An Introduction to the Philosophy of Education*. Macmillan.
- Ellsworth, E. (1989). Why Doesn't This Feel Empowering? Working through the Repressive Myths of Critical Pedagogy. *Harvard Educational Review*, 59(3), 297-324.
- Freire, P. (1970). *Pedagogy of the Oppressed*. Continuum.
- Giroux, H. A. (1983). *Theory and Resistance in Education: A Pedagogy for the Opposition*. Bergin & Garvey.
- Greene, M. (1995). *Releasing the Imagination: Essays on Education, the Arts, and Social Change*. Jossey-Bass.
- Gutmann, A. (1987). *Democratic Education*. Princeton University Press.
- Hutchins, R. M. (1953). *The Conflict in Education in a Democratic Society*. Harper.
- Kliebard, H. M. (1995). *The Struggle for the American Curriculum, 1893-1958*. Routledge.
- McGrath, S. (2010). Beyond Aid: Educating for Sustainable Development in Africa. *International Journal of Educational Development*, 30(2), 144-148.
- Piaget, J. (1970). *To Understand Is to Invent: The Future of Education*. Viking Press.

- Psacharopoulos, G., & Patrinos, H. A. (2004). *Returns to Investment in Education: A Further Update*. *Education Economics*, 12(2), 111-134.
- Sartre, J.-P. (1946). *Existentialism is a Humanism*. Yale University Press.
- Skinner, B. F. (1968). *The Technology of Teaching*. Appleton-Century-Crofts.
- Tilak, J. B. G. (1989). *Education and its Relation to Economic Growth, Poverty, and Income Distribution: Past Evidence and Further Analysis*. World Bank.
- Vygotsky, L. S. (1978). *Mind in Society: The Development of Higher Psychological Processes*. Harvard University Press.